



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/336

Чингис хот

Н.Энхзолбоогийн оршуулгын зардалд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Зарим цогцос оршуулах тухай журмын 1 дүгээр зүйлийн 1.2.1, 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын харьяат А.Мөнхтуяагийн хүү Н.Энхзолбоо нь бичиг баримтгүй, Улсын бүртгэлийн хэлтэст төрөлтийн бүртгэлгүй иргэн байсан тул “Зарим цогцос оршуулах тухай” журмын дагуу оршуулгын зардалд зориулан 1.500.000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА